ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ ХАМААРАЛ БҮХИЙ ХЭСГИЙН 2022ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2022.06.10

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Биелэлт
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
1.	5.1.4.Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.	Тус аймгийн Аялал жуулчлалын бүс Цэнгэл сумын Хотон, Хурган нуурын нарийн гүүрийн дэргэд ОНТөсөвөөс 12 сая төгрөгийн нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж, 2022 онд багтаан барихаар төлөвлөөд байна. Азийн хөгжлийн банкны 2 сая долларын тусламжтай, Алтай таван богдийн нэр бүхий 6 байршилд 2027 онд хүртэл иж бүрэн отоглог, хоноглох цэг барих зураг төслийн ажлууд хийгдэж, батлагдав.
2.	5.1.8.Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд уул уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газар нийт 38.1 га нөхөн сэргээлт хийхдээгүй ба 3 компаний удирдлагад 2022 онд нөхөн сэргэлтийн ажлыг хийж дусгах талаар МХГ,Экологийн цагдаагийн албанаас албан шаардлага хүргүүлэд байна
3.	5.1.11.“Хөх морь” төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна.	БОАЖСайд, тус аймгийн 3Даргын хооронд байгуулсан 2022онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 3-р багийн нутаг дэвсгэрт орших “Устын Рашаан” Ногооннуур сумын “Хавцлын булаг” Алтанцөгц сумын “Чихтэйн булаг” булаг шандыг хамгаалах 9.0сая төгрөгийн сонгон шалгаруулалтыг 2022 оны 05-р сарын 10-наас 2022 оны 09-р сарын 01-ний өдрийн 17:00 цаг хүртэл зарлаж, энэ ондоо багтааж шалгарсан ААНэгжид тус рашаануудын эхийг хамгаалуулахаар төлөвлөн ажиллаж байна.
ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
4.	6.2.10.Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	Аймгийн Засаг даргын А/144 дугаартай захирамж гаргуулан “Цэвэр орчин-хоггүй Өлгий” аян зохион байгуулсан. Уг аяны хүрээнд хийх ажлуудын төлөвлөгөө гаргаж аймгийн хэмжээнд 3 удаа хатуу, эзэнгүй хог хаягдлуудыг цэвэрлэсэн болно. Цэвэрлэгээнд нийт 736 албан хаагч, 600 иргэн, 200 сурагч

			нар оролцож нийтдээ 70 гаруй тонн хатуу хог хаягдлыг цэвэрлэсэн болно. “ Хоггүй цэмцгэр-Өлгий “ аяны хүрээнд СӨХолбооны 10 ажилтан байнга орон сууцын хог хаягдлыг цэвэрлэж, өдөрт 4 машин хог хаягдлыг ачиж нийт аяны хүрээнд 240 тн хогийг нэгдсэн хогийн цэгт хүргүүлсэн. Өлгий сумын 12 багийн дунд “Соёлч өрх” уралдаан зохион байгуулж баг бүрээс орчин тойрныг байнга цэвэрлэж, хог, үнсний сав хийлгэж бусад айл өрхүүдэд үлгэр жичээ үзүүлсэн өрхүүдийг баг шалгаруулж мөнгөн шагнал, өргөмжлөлөөр шагнасан. Өлгий сумын Засаг даргын тамгын газартай хамтарч “Хоггүй Өлгий биднээс эхлэн” анхдугаар зөвлөгөөнд зохион байгуулсан. Уг зөвлөгөөнд 320 гаруй иргэд, Байгаль орчны холбогдох байгууллагад болон ТББайгуулага, Байгаль орчны байгаль хамгаалагч, байцаагч нар оролцсон болно. Холбогдох байгууллагуудтай хамтарч ”Хуванцар савыг хэрэглээнээс хасья” сэдэвт сургалт, сурталчилгааны хамтарсан удирдамж гаргаж, Өлгий сумын 22 цэцэрлэгийн 250 багш, ажилчид болон ахлах, бэлтгэл бүлгийн 800 хүүхдэд сургалт, сурталчилгаа хийж ажиллав.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР